



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БОГД СҮМҮН ЗАСАГ ДАРГА

212208 Хориулт, Богд сум  
Утас: (01-442) 2-65-09

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ  
УХААНЫ АКАДЕМИ, ИТАЛИ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СУДАЛГААНЫ ЗӨВЛӨЛ,  
ИТАЛИ УЛСЫН ВИНЕТО МУЖИЙН  
ЗАСАГ ДАРГА НАР ТАНАА

2006. 08. 22 № 081.

таяй -ны № -т

Гүний худаг гаргах тухай

Та бүгдийн дэмжлэг туслалцаатайгаар манай суманд олон сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж малчдыг нарны зайн эх үүсвэрээр хангах, сургуулийн дотуур байр, хүн эмнэлгийн салбарын гэрэл цахилгааны асуудлыг шийдвэрлэх хүн амыг ундны цэвэр усаар хангах зэрэг олон асуудлыг шийдвэрлэн сум орон нутгийн хөгжилд бодитой дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж байгаа явдалд гүн талархал илэрхийлье. Одоогоор 3 гүн өрмийн худгийн цооногыг өрөмдөн бэлэн болгоод байна. Энэ онд багтаан сумын төвийн хойт хэсэгт 4 дэхь цэгт өрөмдлөг хийж 4 худгийн насос, мотор, барилга байгууламж зэргийг иж бүрнээр барьж хэрэглэгчдэд хүлээлгэн өгөх саналтай байна.

Ирэх 2007 онд дараах газруудад 4 гүн өрмийн худаг гаргуулах саналтай байна.

1. Худаг гаргах цэг .Холбоож нуурын баруун дэнж

Зориулалт.

- Холбоож нуурыг түшиглэн / давс эрдэс шавар / эмчилгээ сувилгааны төв байгуулах
- 1-р багийн төвийн өрхүүдийг ундны усаар хангах

2. Худаг гаргах цэг Хөөврийн дэнж

Зориулалт.

- 2-р багийн айл өрхүүдийг ундны усаар хангах
- Дэлхийд ховордож байгаа хоёр бөхт тэмээг өсгөн үржүүлэх

2. Худаг гаргах цэг .Овоотын үзүүр.

Зориулалт.

- овоот нөхөрлөлийн айл өрхүүдийг ундны усаар хангах
- малын тэжээлийн ургамал тариалах
- нутгийн шилмэл өндөр ашигт шимт малыг өсгөн үржүүлэх

4. Худаг гаргах цэг .Сайрын гээг

Зориулалт.

- Говийн бүсийн томоохон нуурын нэг Орог нуурыг элсний нүүдлээс хамгаалах зорилгоор ойн зурvas байгуулах / 3км /
- 3-р багийн айл өрхүүдийг ундны цэвэр усаар хангах
- Малын тэжээлийн ургамал тариалах

Цаашид бидний хамтын ажиллагаа өргөжин бэхжинэ гэдэгт итгэлтэй байна. Манай орон нутгийн хөгжил цэцэглэлтэнд бодитой дэмжлэг үзүүлж байгаа та бүхэнд нийт ард иргэдийнхээ өмнөөс дахин баярласан талархсанаа илэрхийлж байна.

ЗАСАГ ДАРГА Л.ГАНЗОРИГ.